



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013-05-09 № 01/105

ЭХЯ-ны ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Д. ДЭЛГЭРЦОГТ
ТАНАА

Хөрөнгө оруулалтын төсөл, арга
хэмжээг хэрэгжүүлэх тухай

“ Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийлээ.

Тус яамны төсийн багцад 2012 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар улсын төсвийн хөрөнгөөр батлагдсан хөрөнгө оруулалтаар “Аморе интернэшнл” ХХК-ийн ДЦС-2-ийг түшиглэн “210.0 мянган тн хагас коксжсон түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулах” төсөл, арга хэмжээний барилга угсралтын ажлын гэрээний хугацаа хэтэрч, 2.7 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд дутуу хэрэгжүүлсэн зөрчил, дутагдал илэрлээ.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 27-ны 290 дугаар тушаалаар баталсан “ Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.15, 5.3, 5.5-д заасныг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “... алдаа зөрчлийг арилгуулахаар Төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ НЬ:


1. ДЦС-2-ийг түшиглэн “210.0 мянган тн хагас коксжсон түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулах” ажлын гүйцэтгэл гараагүйгээс гэрээний хугацаа хэтэрч, ажлын гүйцэтгэл гараагүй санхүүжилтийн үлдэгдэл 2.7 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлийг гарган баталгаажуулан 2013 оны 11 дүгээр сард ашиглалтад хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулах арга хэмжээ авч ажиллах,

070252

2. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг гарган 2013 оны 11 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг ЭХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Д.Дэлгэрцогт, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Баярбат нарт хариуцуулан албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлага бичсэн:

ҮАГ-ын аудитор



Ц.Эрдэнэчулуун